



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 52

Мандалговь

"Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх"
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 50,000,000 /тавин сая/ төгрөгийн балансийн үнэтэй үлдэгдэл өртөггүй 00-04 ДУА улсын дугаартай Land cruiser 200 маркын автомашиныг Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Дундговь аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Л.Доржбат), Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1 Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын
30-ны өдрийн 52 дугаар тогтоолын хавсралт

Аймгийн Засаг даргын тамгын газрын тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуриглагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын н дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Суудал	LAND 200	ДВА	00-04	2010	2010.12.15	JTMHU09J 7B5040472		4000	319313	50,000,000	50,000,000	